



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/212

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны “Аймгийн 2021 оны төсөв батлах тухай” 3/03 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2021 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 35 дугаар тогтоолыг тус, тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хэмжээнд “COVID-19”-ийн цар тахлын гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үеийн аймгийн постуудад ажил үүрэг гүйцэтгэсэн байгууллагуудын үйл ажиллагааны зардлын санхүүжилтийн зардалд 80965457.00 хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Тус арга хэмжээнд зарцуулах нийт 80965457.00 төгрөг /наян сая есөн зуун жаран таван мянга дөрвөн зуун тавин долоон/-ийг аймгийн техник хяналтын зардлын данснаас дараа тооцоогоор зохицуулж санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

3. Аймгийн техник хяналтын зардлаас дараа тооцоогоор санхүүжүүлсэн 80965457.00 төгрөгийг аймгийн 2021 оны төсөвт тухайн зардлын батлагдсан эх үүсвэрээс нөхөн тооцоо хийж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/212 Ch.
02 1224

Аймгийн Засаг даргын 2021 оны 04
дүгээр сарын 27-ны өдрийн
А/212 дугаар захирамжийн хавсралт

АЙМГИЙН ПОСТУУДАД АЖИЛ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭСЭН БАЙГУУЛЛАГУУДЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ТООЦОО

/мянган төгрөгөөр/

ДД	Шатахуун	Хоол	Эм, хэрэгсэл	Ариутгал	Тусгаарлах байр	Дүн	Олгох 50.0 хувийн санхүүжилт
1	ОБГазар	62105000.00	2000000.00		45605000.00	115886300.00	57943150.00
2	Мянгад сум	2294200.00				2474200.00	1237100.00
3	Дарви сум	664320.00				664320.00	332160.00
4	Цагдаагийн газар	517500.00	539500.00			3923050.00	1961525.00
5	Тагнуулын газар	2000000.00				2000000.00	1000000.00
6	ХОВД ЖЮЛИ ХХК			22533600.00		22533600.00	11266800.00
7	Мал эмнэлгийн газар	589200.00		4303445.00		4892645.00	2446322.50
8	ЗООНОЗ өвчин судлалын төв	1320000.00	5212300.00			6532300.00	3266150.00
9	Хүнс, хөдөө аж ахуйн газар	783750.00		858500.00		1642250.00	821125.00
10	БОЭТӨВ	1382250.00				1382250.00	691125.00
	Дүн	64916700.00	7751800.00	27695545.00	45605000.00	161930915.00	80965457.50

-000-